

**“*Jus cogens*” хэм хэмжээ: Төрлөөр устгах гэмт хэргийг
тодорхойлох онолын ойлголт, дотоодын эрх зүйн
зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд**

**The Doctrine of Jus Cogens: Conceptual Foundations for
Defining the Crime of Genocide and Issues in Improving
Domestic Legal Regulation**

Батхуягийн Алтангэрэл

Хууль зүйн ухааны магистр (LL.M).

*Хуульч, Монгол Улсын Дээд шүүхийн хэргийн
хөдөлгөөн, мэдээлэл, судалгааны хэлтсийн судлаач*

Улаанбаатар хот, Монгол Улс

lawfirmaltangerel@gmail.com

© B.Altangerel, 2026



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Энэ өгүүлэл нь олон улсын эрх зүйн зайлшгүй дагаж мөрдөх *jus cogens* хэм хэмжээний хүрээнд төрлөөр устгах (геноцид) гэмт хэргийг онолын болон эрх зүйн үүднээс тодорхойлох, манай улсын эрх зүйн тогтолцоонд хэрхэн туссан, түүнийг хэрхэн боловсронгуй болгох талаар судалсан болно.

Монгол Улсад төрлөөр устгах гэмт хэргийг Эрүүгийн хууль тогтоомжид тусгах үйл явц түүхэн хувьд удаашралтай явагдсан бөгөөд зөвхөн 2002 оноос анх удаа бүрэн хэмжээний гэмт хэрэг болгон хуульчилсан нь судалгааны нэг онцлох ажиглалт юм. Өнөөгийн Эрүүгийн хууль (2017 он) төрлөөр устгах гэмт хэргийн олон улсын стандарттай ихэнх талаар нийцэж байгаа боловч бүлгийн сэтгэцэд учруулах хохирол, “албадан зайлуулах” ойлголтын тодорхойлолт зэрэг зарим зохицуулалт тодорхой бус хэвээр байгааг судалгаа дүгнэн харууллаа.

Өгүүллийн үр дүнд Монгол Улсын эрүүгийн эрх зүйг олон улсын хэм хэмжээтэй илүү нийцүүлэх, урьдчилан сэргийлэх механизмыг боловсронгуй болгох, нотлох баримтын стандартыг тодруулах зэрэг бодлогын түвшний зөвлөмжийг дэвшүүлэв. Судалгаа нь Төрлөөр устгах гэмт хэргийн ойлголтыг онол-практикийн үүднээс нарийвчлан тодорхойлж, дотоодын эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

[Түлхүүр үг]

Jus cogens; Төрлөөр устгах гэмт хэрэг; Олон улсын эрүүгийн эрх зүй; *Dolus specialis*; ICTY; ICTR; ICC; Монгол Улсын Эрүүгийн хууль; Урьдчилан сэргийлэх тогтолцоо; Хүний эрхийн хамгаалалт.

I. Удиртгал

Төрлөөр устгах гэмт хэрэг нь олон улсын гэмт хэрэг бөгөөд дэлхийн хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн жигшүүрт гэмт хэргийн нэг юм. Энэ нь үндэстэн, угсаатны, арьс өнгө, шашны бүлгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устгах зорилготойгоор зориудаар, системтэйгээр устгах явдал билээ.

Олон улсын хэм хэмжээ, номлолын дагуу төрлөөр устгах гэмт хэрэг нь *jus cogens* хэм хэмжээ гэж тооцогддог бөгөөд бүх нийтээрээ төрлөөр устгах гэмт хэргийг хориглох үүргээс татгалзаж үл болно. Төрлөөр устгах гэмт хэргийн зохицуулалтын хэрэгжилтийг Руандагийн Олон улсын эрүүгийн шүүх (ICTR), Хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүх (ICTY), сүүлийн үед Олон улсын эрүүгийн шүүх (ICC) зэрэг олон улсын шүүхээр дамжуулан хэрэгжүүлж байна. Хэдийгээр тодорхой эрх зүйн зохицуулалт хүчин төгөлдөр хэрэглэсээр ирсэн хэдий ч улс төр, дипломат болон нотлох баримтын нарийн төвөгтэй байдлаас үүдэн төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариуцлага ногдуулахад бэрхшээлтэй хэвээр байна.

Төрлөөр устгах гэмт хэргийг хүлээн зөвшөөрч, эрүүгийн хариуцлага ногдуулах нь олон улсын хамтын нийгэмлэг хүний нэр төрийг сахин хамгаалах, үй олноор харгис хэрцгийгээр устгах үйлдлээс урьдчилан сэргийлэх явдлыг илэрхийлж байгаа ч, сүүлийн жилүүдэд хүн төрөлхтний дунд гарч буй гэмт хэргийн шалтгаанууд, үйл олноор амь үрэгдэж буй явдалд төрлөөр устгах гэмт хэргийн зарим шинж агуулагдаж буй нь энэ төрлийн гэмт хэргийг тодорхойлоход мөн л бэрхшээл дагуулсаар байгаа.

Монгол Улс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нэлээд олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон боловч дотоодын эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг мөн дурдаж болно. Эрх зүйн тус салбар нь олон улсын хамтын ажиллагааны аргагүйдсэн зайлшгүй арга хэмжээ болохын хувьд эрх зүйн үндсэн дээр байнга боловсронгуй болсоор байна.

Иймд энэхүү судалгаагаараа олон улсын гэмт хэргийг онолын үүднээс тодорхойлох, тэр дундаа төрлөөр устгах гэмт хэргийн элемент, шинжийг тодорхойлж сүүлийн үеийн илрэн гарах хэлбэрүүдийг дэлгэрүүлэх чухал ач холбогдолтой юм. Ийнхүү олон улсын гэмт хэргийн төрлөөр устгах гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүнийг нарийн тодорхойлсны үндсэн дээр тэдгээрийн олон улсын эрх зүйн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийж, дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, авах арга хэмжээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйг харьцуулан судалснаараа

ЭНЭХҮҮ СУДАЛГАА НЬ ОНЦЛОГТОЙ ХЭМЭЭН СУДЛААЧИЙН ЗҮГЭЭС ҮЗЭЖ БАЙНА.

II. Төрлөөр устгах (геноцид) гэмт хэрэг, түүнд ногдуулах эрүүгийн хариуцлагын онцлог

Төрлөөр устгах гэмт хэргийн шинж, түүний бүрэлдэхүүн

Төрлөөр устгах гэмт хэргийн объектив тал.

Гэмт хэргийн Объектив талын шинж нь төрлөөр устгах гэмт хэргийн физик үйлдэл, эрх зүйн, нийгмийн байдал, үйл явц буюу тухайн гэмт үйлдлийг тайлбарлахад илүүтэй анхаардаг.¹

Төрлөөр устгах гэмт хэргийн субъектив тал.

Төрлөөр устгах гэмт хэргийн субъектив тал нь гэмт хэрэгтний сэтгэл зүй, нийгмийн хандлага, эрх мэдлийн харилцаа холбоо, зорилго, сэдэлтийг тодорхойлдог.

Төрлөөр устгах гэмт хэргийн субъектив тал нь тухайн гэмт хэргийг үйлдэх этгээдийн дотоод сэтгэл санааны байдал, зорилго, ухамсартай үйлдлийг харуулдаг. Энэ нь гэмт хэргийг гүйцэтгэхэд оролцсон этгээдүүдийн бодит зорилго, шууд болон шууд бус санаанд анхаардаг бөгөөд дараах онцлог шинжүүдтэй:

Төрлөөр устгах гэмт хэрэг нь заавал шууд санаатай (Dolus Directus)² буюу тодорхой бүлгийг устгах зорилготой байх ёстой. Энэ нь гэмт хэргийг гүйцэтгэгч этгээд тухайн бүлгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн устгахыг зориуд ухамсарлаж, үйлдэл хийсэн гэсэн үг юм. Төрлөөр устгах гэмт хэрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэргээс ялгаатай нь **санаа зорилгын өндөр шалгуур** шаарддаг. Үүнд **ерөнхий санаа** буюу хүчин төгөлдөр гүйцгэсэн үйлдэл нь өөрөө гэмт хэрэг болох ёстой. Жишээ нь, хүмүүсийг хөнөөх, гэмтээх гэх мэт. Мөн **тусгай санаа (Dolus Specialis)** буюу тодорхой бүлгийг устгах зорилготойгоор хийдэг явдал юм. Энэ санаа зорилго нь төрлөөр устгах гэмт хэргийг бусад төрлийн гэмт хэргээс ялгаруулдаг.

Мөн бүлгийг нь устгах бодлого хэрэгжүүлэх; бүлгийн амьдрах орчныг зориуд хордуулах, хүнсний хомсдол үүсгэх гэх мэтээр амьдрах нөхцөлийг үгүй хийх гэх мэтээр устгах үйлдэл хийхдээ гэмт хэрэг үйлдэгч өөрийн хийж буй үйлдлийн үр дагаврыг бүрэн ухамсарласан байхыг шаардана.

Эдгээрээс үзвэл төрлөөр устгах гэмт хэргийн субъектив тал нь зориуд санаатай, үйлдлийнхээ хор уршгийг ухамсарласан эсхүл

¹ Содовсүрэнгийн Нарангэрэл, Эрх зүйн тайлбар толь, (Улаанбаатар: 2000), 312 дахь тал

² Johan Van der Vyver, “The International Criminal Court and the Concept of Mens Rea in International Criminal Law”, University of Miami International & Comparative Law Review, (2007), 57.

ухамсарлах бүрэн боломжтой, тухайн халдаж буй бүлгийг зориуд устгах зорилготой байдалд тулгуурладаг бөгөөд энэ нь тухайн гэмт хэргийг хүн төрөлхтний эсрэг бусад гэмт хэргүүдээс ялгагдаг байна.

Төрлөөр устгах гэмт хэрэгт хүлээлгэх олон улсын эрүүгийн хариуцлага: Төрлөөр устгах гэмт хэрэгт ногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ нь олон улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ, болон тухайн улсын үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байдаг. Учир нь дийлэнх тохиолдолд тухайн улсад үйлдэгдсэн төрлөөр устгах гэмт хэргийг улс дотроо гэхээс илүүтэйгээр олон улсын оролцоотойгоор шийдвэрлэдэг байна. Олон улсын болон үндэсний хуулиудад энэ төрлийн гэмт хэргийг онц ноцтой, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцдог учир шийтгэл нь маш хүнд байдаг.

Олон Улсын Шүүхийн хариуцлага: Олон улсын түвшинд төрлөөр устгах гэмт хэргийг шийдвэрлэхийн тулд НҮБ-ын Олон улсын эрүүгийн шүүх (ICC), Югославын Олон улсын эрүүгийн шүүх (ICTY), Руандагийн Олон улсын эрүүгийн шүүх (ICTR) зэрэг шүүхүүд үйл ажиллагаа явуулдаг. 1948 оны НҮБ-ын «Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц» нь төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага тооцох заалтыг тусгасан бөгөөд энэ нь шүүхийн үндсэн баримт бичиг юм.³ Төрлөөр устгах гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага нь хэд хэдэн үндсэн онцлогтой. *Эдгээрийг дэлгэрүүлбэл:*

- **Гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага:** Төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр бэлтгэсэн, зохион байгуулсан, түүнд оролцсон этгээдүүд олон улсын эрүүгийн шүүхээр шүүгдэж, бүх насаар нь хорих ял хүртэл хүнд шийтгэл хүлээдэг.

- **Хамтран оролцсон этгээдүүдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага:** Төрлөөр устгах гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, тусалсан буюу хамтран оролцсон этгээдүүд ч мөн адил гүйцэтгэсэн этгээдийн адил хариуцлага хүлээх зарчмыг баримталдаг байна.

- **Эд хөрөнгө, иргэний эрхийг хасах:** Зарим тохиолдолд шүүх төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн эд хөрөнгийг хураах, тодорхой иргэний эрхийг хасах шийдвэр гаргаж болно.

Үндэсний Хууль Тогтоомжийн хүрээнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага: Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцод нэгдэн орсон олон улс дотоодын хууль тогтоомждоо тусгаж, тус төрлийн гэмт хэргийг дотооддоо шийдвэрлэх үүрэгтэй. 2024 оны байдлаар,

³ Understanding the International Criminal Court, (2020), <https://www.icc-cpi.int/sites/default/files/Publications/understanding-the-icc.pdf>

нийт 152 улс энэхүү конвенцод нэгдэн орсон байна. Үүнд дэлхийн бүс нутгуудын ихэнх улс орнууд багтдаг бөгөөд тэдгээр нь төрлөөр устгах гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, түүнд шийтгэл оногдуулах үүрэг хүлээсэн байдаг. Гэсэн хэдий ч, зарим улс орнууд одоог хүртэл конвенцод нэгдээгүй байна. Тухайлбал, Япон, Индонез, Малайз, Непал, Бутан, Сингапур зэрэг улсууд конвенцод нэгдээгүй хэвээр байна.

Дийлэнх улсууд төрлөөр устгах гэмт хэргийг дотоодод үйлдэгддэг гэмт хэргийн нэгэн адил Эрүүгийн хуульдаа тусгасан байдаг. Монгол улсын хувьд төрлөөр устгах гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг мөн адил Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга) 2015- даа тусган зохицуулж байна. Монгол улсын төрлөөр устгах гэмт хэрэгт авах арга хэмжээний талаар судалгааны бүтээлийн дараагийн хэсэгт дэлгэрүүлэн авч үзэх болно.

Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шүүхийн хяналт: Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариуцлага хүлээлгэх нь олон улсын хууль, гэрээ хэлэлцээрт тусгагдсан зарчмын асуудал юм. НҮБ-ын Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцоор дан ганц эрүүгийн хариуцлага хүлээлгэх бус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэрэв гарсан тохиолдолд шүүх хяналтад оруулах үүргийг хүлээдэг. Олон улсын шүүхүүд төрлөөр устгах гэмт хэрэгт тавьж буй хяналтыг авч үзвэл:

Нюрнбергийн Шүүх Хурал (1945-1946): Дэлхийн II дайны дараа Германы нацист удирдагчид болон төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг хариуцлагад татахын тулд Нюрнбергийн шүүх хуралдааныг зохион байгуулсан. Нацист Германы дэглэм Холокост буюу Еврей үндэстний эсрэг төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн хэргээр олон удирдагчид болон офицеруудыг буруутгаж, хүнд шийтгэл оноосон⁴. Үүний үр дүнд олон нацист удирдагч цаазын ял, бүх насаар нь хорих ял хүлээсэн байдаг. Тухайлбал тус гэмт хэргийг удирдан чиглүүлэх үүрэгтэй оролцож байсан **Герман Геринг, Рудольф Хесс** зэрэг өндөр албан тушаалтай удирдагчид хүнд ял шийтгэл хүлээсэн⁵. Тус тохиолдол нь төрлөөр устгах гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг олон улсын эрүүгийн эрх зүйд анх удаа тусгаж, олон улсын жишиг тогтоосон онцлох үйл явдал байв.

Руандагийн төрлөөр устгах гэмт хэрэг болон Руандагийн Олон Улсын Эрүүгийн шүүх (ICTR) (1994): 1994 онд Руандад тутси угсаатны эсрэг үй олноор нь хоморголон устгах үйл ажиллагаа

⁴ Ann Tusa, John Tusa, The Nuremberg Trial. Atheneum, (1983), 386

⁵ Alison Des Forges, Leave None to Tell the Story: Genocide in Rwanda, (Human Rights Watch, 1999), 125.

явагдсан. Энэ явдал 100 хоногийн дотор 800,000 гаруй хүн амь үрэгдсэн аймшигт төрлөөр устгах гэмт хэрэг болж, олон зуун мянган хүн хохирсон. Руандагийн Олон улсын эрүүгийн шүүх (ICTR) хуралдаж, төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг шүүхээр шийтгэсэн.⁶ Үүний хүрээнд Руандагийн геноцидийг удирдсан Хуту үндэстний зэвсэгт бүлэглэлийн удирдагчид болон дэмжигчид олон улсын эрүүгийн шүүхээс бүх насаар хорих болон урт хугацааны хорих ял шийтгэгдсэн.

Югославын Олон Улсын Эрүүгийн Шүүх (ICTY) ба Сребреницагийн Төрлөөр устгал (1995): Хуучин Югослав улс задарсны дараа Боснийн дайн болж, 1995 онд Сребреница хотод 8,000 орчим Боснийн мусульман эрэгтэйчүүд болон хөвгүүдийг сербийн цэргүүд үй олноор нь хөнөөсөн. Үүнийг олон улсын шүүх төрлөөр устгах гэмт хэрэг гэж үзэж, Югославын Олон улсын эрүүгийн шүүхээс гэмт хэрэгтнүүдэд хариуцлага хүлээлгэсэн⁷. Эл үйл явдлын хүрээнд Боснийн Сербийн удирдагч **Радован Караджич** болон генералуудыг бүх насаар нь хорих ялаар шийтгэсэн.

Камбожийн «Улаан Кхмерийн» Төрлөөр устгах гэмт хэрэг ба Камбожийн төрлөөр устгах гэмт хэргийг шийдвэрлэсэн жишээ (1975-1979): Камбожид Улаан Кхмерийн дэглэм 1975-1979 онд Пол Потын удирдлага дор сая гаруй хүнийг хоморголон устгаж, аймшигт геноцид үйлдсэн. Энэхүү гэмт хэргийг үйлдсэн удирдагчид нь олон жил өнгөрсний дараа Камбожийн төрлөөр устгах гэмт хэргийн шүүхээр шүүгдэж, шийтгэл хүлээсэн⁸. Үүнээс Улаан Кхмерийн гол удирдагч **Нуон Чеа, Киу Сампан** нарыг төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгаж бүх насаар нь хорих ял оноосон.

Эдгээр жишээнүүд нь төрлөөр устгах гэмт хэрэг буюу төрлөөр устгах гэмт хэргийг үйлдсэн этгээдүүдэд олон улсын түвшинд болон дотоодын хууль эрх зүйн хүрээнд хариуцлага ногдуулж байсныг илтгэдэг сонгодог жишээнүүд юм. Олон улсын эрүүгийн шүүхүүд энэ төрлийн хэргийг мөрдөн шалгаж, шийдвэр гаргах нь улс орнууд болон олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс төрлөөр устгах гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чухал механизм болж байна.

⁶ Des Forges, A., *Leave None to Tell the Story: Genocide in Rwanda*. Human Rights Watch, (1999), 125

⁷ John Hagan, *Justice in the Balkans: Prosecuting War Crimes in the Hague Tribunal*. (University of Chicago Press: 2003), 89-90

⁸ Craig Etcheson, *After the Killing Fields: Lessons from the Cambodian Genocide*. Praeger Security International, (2005), 65

III. Монгол улсын хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжид төрлөөр устгах гэмт хэрэг тусгагдсан байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ; Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” хэмээн заасан.

Үүний хүрээнд нэлээдгүй олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж, соёрхон баталсны нэг нь НҮБ-аас батлан гаргасан “Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ...тухай” конвенц юм. Манай улс 1948 оны 12 дугаар сард батлагдаж 1951 онд хүчин төгөлдөр болсон “Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц”-д 1966 онд нэгдэн орж, соёрхон баталсан. Гэсэн хэдий ч төрлөөр устгах гэмт хэргийг тус конвенцыг соёрхон баталснаас 40 орчим жилийн дараа буюу 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид анх удаа гэмт хэрэг болгон хуульчилсан.

Улмаар Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга (2017)-ийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт “Үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор хүнийг алсан, эсхүл хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан, эсхүл төрөлтийг хүчээр зогсоосон, эсхүл хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан, эсхүл амьдралын өөр нөхцөл бий болгох замаар тэднийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн устаж үгүй болоход хүргэсэн, эсхүл хүчээр сураггүй алга болгосон бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ” хэмээн заасан байна.

Манай улсын Эрүүгийн хуульд төрлөөр устгах гэмт хэргийг хуульчилсан нь тухайн гэмт хэргийн бүрдлийг хангах хэд хэдэн шинжийг тусгажээ. Энэ нь НҮБ-аас баталсан төрлөөр устгах гэмт хэргийн шинжээс бага зэрэг зөрүүтэй байна. Тухайн гэмт хэрэгт өртөж болох бүлгийн нийтлэг шинжийг манай улсын эрүүгийн хуульд “Үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлэг” гэсэн бол Төрлөөр устгах гэмт хэргийн тухай НҮБ-н конвенцод “үндэс, угсаа, арьс үндэс буюу шашин шүтлэг нэгтэй бүлэг” хэмээн тодорхойлсон нь бичвэрийн хувьд өөр боловч утгын хувьд ижил байна. Тус конвенцод бүлгийн гишүүдийн амь насыг хороох; бүлгийн гишүүдийн бие махбод, сэтгэцэд ноцтой гэмтэл учруулах; бүлгийг бүхэлд нь буюу түүний хэсгийг бүрэлгэн устгахад чиглэсэн амьдрал, ахуйн нөхцөлийг санаатайгаар бий болгох; бүлгийн дотор төрөлт зогсооход чиглэсэн арга хэмжээ авах; хүүхдүүдийг нэг бүлгээс нөгөөд

хүчээр шилжүүлэх зэрэг агуулга нь манай улсын Эрүүгийн хуульд бүрэн туссан байна. Харин онцлог зохицуулалт нь Конвенцод хүний бүлгийн гишүүдийн бие махбод болон сэтгэгцэд ноцтой гэмт учруулах хэмээн бүлгийн гишүүдийн эрүүл мэндийн халдашгүй байдал болон сэтгэцийн халдашгүй байдлыг хамтад нь тусгасан байна. Харин МУ-ын Эрүүгийн хуульд зөвхөн бүлгийн гишүүдийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан тохиолдлыг төрлөөр устгах гэмт хэргийн объектив шинжид хуульчилсан бөгөөд сэтгэгцэд учирсан хохирлыг хуульчлаагүй байна.

Конвенцод “ноцтой” хохирол шаардахаар тусгасан бол МУ-ын Эрүүгийн хуульд “хүнд” хохирол байхаар хуульчилжээ. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ хуульд заасан «ноцтой хохирол, хор уршиг» гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно” хэмээсэн бол хүнд хохирол гэдэгт илүү эрүүл мэндэд учирсан хохирол буюу Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Гэмтлийн зэрэг тогтоох журам”-д зааснаар “гэмтэх үед амь нас хохирч болох амь тэнссэн байдалд хүргэсэн буюу ердийн явцаараа ихэвчлэн үхэлд хүргэх гэмтэл, гэмтлээс үүссэн үлдэц, уршиг, хөдөлмөрийн ерөнхий чадвар их хэмжээгээр алдагдсан гэмтэл” хэмээн тодорхойлж байв. Улмаар шинэчлэгдэн батлагдсан Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/225/А/153/А/85 дугаар тушаалын хавсралт “Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасанчлан “Амь насанд аюултай, тус журамд нэрлэн заасан гэмтлүүд”-ийг хамааруулан авч үзсэн байна.

Эрүүгийн хуульд Төрлөөр устгах гэмт хэргийг хуульчилсан объектив тодорхойлолтуудыг авч үзвэл, Хүнийг алсан гэж үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор, хүний эрүүл мэндэд санаатай хүнд хохирол учруулсныг ойлгох бол төрөлтийг хүчээр зогсоосон гэж үндэс угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор ураг зулбуулсан, үр хөндсөн, жирэмслэлтийг таслан зогсоосон, нөхөн үржихүйн эд эрхтнээс хагацуулсныг ойлгоно” гэжээ. Харин “Хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан гэж үндэс, угсаа, арьсны өнгө, зэргээр ялгаварлан тухайн бүлгийг устгах зорилгоор бусад бүлэгт хүчээр шилжүүлснийг ойлгох бол “Амьдралын өөр нөхцөл бий

болгох замаар тэднийг бүхэлд нь , эсхүл хэсэгчлэн устаж үгүй болоход хүргэсэн гэж ... зорилгоор амьдарч буй газар нутгаас зайлуулах, үржил шимгүй нутаг зааж явуулах, амьдрах орчныг бохирдуулах, хордуулах, эрхэлдэг аж ахуйг сүйрүүлэх, халдварт өвчин тараах, хүнс тэжээлийн эх үүсвэрийг устгах, амьдралын нөхцөлийг өөрчлөх зэргээр өлсгөлөн, өвчин эмгэг тусч устах нөхцөлийг бүрдүүлэхийг ойлгоно” гэж тус тус тайлбарласан.

Гэсэн хэдий ч Эрүүгийн хуулийн тусгай болон ерөнхий ангийн талаар тайлбар бүтээлүүдэд “албадан зайлуулсан” хэмээх ойлголтыг тайлбарласан тайлбар байхгүй байна. Өөрөөр хэлбэл “албадан зайлуулах” гэдгийг өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж болон 2002 оны Эрүүгийн хууль, түүний албан бус тайлбар, эрдэмтэн судлаачдын тайлбарт дурдаагүй, ямар нэгэн тайлбар байхгүй байна. Харин 1942 оны Эрүүгийн хуульд мөн л “албадан зайлуулах” хэмээх нэр томъёог ашигласан байх ба энэ нь ялын төрөл болгон хуульчлагдаж байжээ. Албадан зайлуулах гэдэг нь “Ямар нэг нутгаас өөр нутагт албадан зайлуулах буюу аль нэг аймагт оршин суухыг цаазлах буюу цаазлахгүйгээр зайлуулах” хэмээн тус Эрүүгийн хуульд тусгасан байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга (2015)-ын төслийн үзэл баримтлалд “Гэмт хэргийн тухай хуулийн төслийн зорилтыг шинээр томъёолж хүний эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан нийтлэг ашиг сонирхлыг нэн тэргүүнд авч үзэж, Монгол Улсын Үндсэн хуульт байгуулал, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх байдлаар эрэмбэлнэ” хэмээн заасан нь мөн төрлөөр устгах гэмт хэргийг хуульчилсан байдалд тусгагдсан.

2015 оны Эрүүгийн хуульд төрлөөр устгах гэмт хэргийн объектыг тусгахдаа “бүлэг” буюу тодорхой шинж бүхий бүлгийг устгах явдлыг хуульчилжээ. Харин 2002 оны Эрүүгийн хуульд “хүн ам” хэмээн хуульчилсан нь тодорхой нэг үндэстнээс бүрдсэн хүн ам буюу бүлгийг устгах үйлдлийг гэмт хэрэгт хамааруулсан давуу талтай байх боловч, нөгөөтээгүүр хүн төрөлхтний эсрэг бусад гэмт хэргүүдээс ялгахад төвөгтэй байдлыг үүсгэж байсан байж болзошгүй юм.

Түүнчлэн өмнө нь тодорхой бүлэг, хүн амын гишүүдийг устгах зорилгоор халдан хүнд гэмтэл учруулсан тохиолдлыг хуульчилсан бол 2017 оны Эрүүгийн хуульд “хүндэвтэр” хэмээн хохирлын хэмжээг тусгажээ. Мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад орсон онцлог зохицуулалт нь төрлөөр устгах гэмт хэрэгт ногдуулах эрүүгийн хариуцлагын хэмжээ юм.

IV. Төрлөөр устгах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар дотоодын практик судалгаа

Монгол Улсын хэлмэгдүүлэлт ба төрлөөр устгах гэмт хэрэг

Хэлмэгдүүлэлтийг төрлөөр устгах гэмт хэрэг хэмээн үзэхэд төрлөөр устгах гэмт хэргийн хэд хэдэн шинжийг агуулсан байхыг шаардана. Хамгийн гол нь тодорхой бүлэг хүмүүсийг устгах зорилгоор хийсэн үйлдэл байх ёстой. Монгол улсын хэлмэгдүүлэлтийн хувьд 2 төрлийн бүлэг хүмүүсийг устгах зорилго бүхий үйл ажиллагаа өрнөсөн нь түүхийн хуудаст тэмдэглэгдэн үлджээ. Үүний нэг нь 1.Шашны холбогдолтойгоор лам нарыг устгах үйл ажиллагаа бол нөгөө нь 2.Улс төрийн сэхээтнүүдийг хоморголон устгах үйл ажиллагаа юм.

1921-1937 он хүртэлх арван зургаан жилийн хугацаанд монголын түүхэнд хувьсгалт шинжтэй олон үйл явдал болж өрнөсөн. Үзэл баримтлал, хөгжлийн чиг хандлагын зөрчлөөс үүдэн хувьсгалт төрд тэрсэлсэн хэргээр хамтран зүтгэгчдээ ганц нэг бүхэл хэсгээр цаазлан хороож хөрөнгө тэгшитгэх нэрээр ард иргэдийнхээ эд хөрөнгөнд халдаж, Коминтерныг хүсэл зоригийн хүрээнд төрийн эргэлт хийсэн эгзэгтэй он жилүүд байв. Энд Шашин сүм хийдийн талаарх И.В.Сталины байр суурийг авч үзэх нь зүйтэй⁹. Уг асуудлыг ойлгох түүний үзэл ихээхэн зөрчилтэй бөгөөд бүхэлдээ юуны урьд лам нарыг хувьсгалын эсэргүү хэмээн үзэхэд үндэслэж тэдний эсрэг хүч хэрэглэхэд чиглэгджээ. Энэ нь “Зүүний” нугалааны үед лам нар, сүм хийдийн асуудлыг завхруулснаас эхлээд “Лхүмбийн хэргээр” дамжин 1930-аад оны эцсээр хорь шахам мянган лам нарыг хэлмэгдүүлсэн завхрал 1940-өөд онд лам нарын сүүлчийн хэсгийг хороосон явдлуудаар үндсэндээ дууссан үйл явдал байсан¹⁰.

Коминтерны сүм хийдийн талаарх бодлого маш нарийн явагдсан. Тэд эхлээд лам нарын эд хөрөнгийг хураах тогтоол гаргаж ард амьдрал руу өөрсдөө ороход нь түлхэж байв. Тухайн үед ардын засгаас гаргасан тогтоолд “Феодал” хэмээгчдийн хөрөнгийг хураах ажилд 100 ба түүнээс дээш хувийн хөрөнгө 920 гаруй өрхийг хамарч, тэднээс 729 нь тухайн үеийн ханшаар 5.2 сая гаруй төгрөгийн үнэ бүхий мал ба үл хөдлөх хөрөнгөө хураалгажээ. Түүнчлэн уг тогтоолд: “Эдгээр этгээдийн хөрөнгийг шууд хурааж, өөрийн аж амьдралыг сайжруулах үндсэн хөрөнгө болговоос зохимуй” хэмээгээд феодалын хөрөнгийг хэрхэн хураах зааврыг баталсан байна. 100 хувь хөрөнгө нь тэр үеийн ханшаар бол 3000 төгрөг, эсхүл 60 тэмээ, эсхүл 100 адуу,

⁹ Соводсүрэнгийн Нарангэрэл, Монголын Их Хэлмэгдүүлэлт, Монголын 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн түүхэн явц, түүний үр дагавар, архивын баримт материалд тулгуурласан судалгаа.

¹⁰ С.Эрдэнэболд, “Монголын түүхэн хэлмэгдүүлэлт ба хүний эрх”, Хэлмэгдүүлэлтийн хүний эрхийн зөрчил, түүхэн үр дагаврын талаар судалсан бүтээл.

эсхүл 100 үхэр, эсхүл 500 хоньтой тэнцэж байжээ.

Энэ тухайн Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга З.Шинжээ хэлсэн үгэндээ, уг үйл явдлыг феодал лам нартай эсэргүүцэн тэмцэх явдлын дотор анх тэргүүнээ эхлэн явуулсан нэгэн чухал хэрэг хэмээн дүгнээд энэ хэргийг гүйцэтгэн явуулахад 427 феодал ба хутагт хувилгаад, 302 түшмэдээс 4793392 төгрөг 89 мөнгөний үнэтэй мал 358952 төгрөг 36 мөнгөний үнэ бүхий зүйл ба 70225 төгрөг 50 мөнгөний үнэтэй үл хөдлөх хөрөнгө бүгд нийлсэн 5222567 төгрөг, 72 мөнгөний үнэтэй юмсыг хураасан, хураасан мал ба хөрөнгө зоориноос 1560436 төгрөг 70 мөнгөний үнэ бүхий зүйлүүдийг ядуу ардуудад шилжүүлэн өгснөөс гадна бусад мал ба хөрөнгө зоорийг нь 130 хамтралуудад хуваан өгсөн гэж тэмдэглэжээ.

Тухайн үед бурхан шашныг шүтэх үзэлд Монголчууд хүчтэй ууссан байсан бөгөөд энэ тухай “Намын доторх зүүн жигүүрийнхний эрмэлзэх санал”-д “Шашин лам нарын элдэв идэвх хөдөлгөөн улс төрийн явуулгыг устгах тухай” гэсэн заалт олныг хөндөж Дамбадорж хэлэхдээ “Тус Монголын одоогийн байдлыг үзвээс харьяат олон ард түмэн бурхан шашныг итгэж сүсэглэх явдал гүн зузаан учир хэрэв хөдөө хотын олон ард дор бурхан шашин хэрэг үгүй хэмээн дэлгэрүүлэх дор бэрх юм. Бидний намын түмэн илүү гишүүдийн дотор бурхан шашныг тахих сүсэглэхгүй этгээд цөөхөн гарах буй за” хэмээжээ. Харин Коминтерны зүгээс лам нар танай улсын дайсан, лам нараа устга гэдэг үгийг үргэлж тулгаж байв. Зөвлөлтийн дотоод явдлын яамны сургагч байсан Чибисов БНМАУ-д айлчлаад буцахдаа /1934 оны 12 сарын 31/ БНМАУ-ын дотоодыг хамгаалах газрын дарга Д.Намсрайд захиас болгож “Сталин урьд хэлэхдээ лам нар цөмөөрөө эсэргүү этгээд мөн. Гагцхүү тус орон нутгаас урвасан хэмээн илээр олны өмнө шийтгэх хэрэгтэй. Дээд лам нар чинь байдал тайван байна. Иймд үүнийг хэвээр тайван байлгах явдалгүй. Лам нарын талаар цохилт өгөх хэрэгтэй” гэжээ. Энэхүү зөвлөгөө Сталины уг санаа бүрэн мөгийг 1934-1936 онд ерөнхий сайд П.Гэндэн, А.Амар нартай Москвад хийсэн уулзалтын үеэр түүний хэлсэн үгнээс нотлогдож байна. Сталин 1934 онд П.Гэндэн, Р.Мэнд нартай уулзахдаа лам нарын талаар “гойрон бүслэх”¹¹ арга хэрэглэхийг зөвлөжээ. Түүнчлэн Коминтерны сургагч нар Сталины даалгавраар зориуд сүм хийд лам нарын эсрэг турхирч байсан тухай сургагч М.Амагаеваас Ф.Ф.Петровт илгээсэн захидлаас харж болно. Уг захидлын хэсгээс авч үзвэл “... тухайлбал бүх материалыг нарийвчлан судлах, лам нарын дунд зохиох намын чиг шугам ба төлөвлөгөөг бүрэн гүйцэд зохицуулах хүртэл лам нарын асуудлаар тавих илтгэлийг зориуд хойшлуулж байв. Одоо Төв хороонд лам нарын асуудлаар нийтлэг

¹¹ Үнэн сонин, (1990.08.05), 3 дахь тал.

ойлголт хандлагатай болж чадсан бөгөөд төв хорооны эгнээн дотор энэ асуудлаар ямар нэгэн зөрөлдөөн гарна хэмээн эмээх зүйлгүй боллоо. Таны өгсөн удирдамжуудыг лам нарын асуудлаар намаас явуулах бодлогын үндэс болгосон юм”¹² хэмээн бичсэн байна.

Энэ баримтаас харахад урьд намын дотор бидний бодлогыг эсэргүүцдэг хэсэг бүлэг байсан бид тэдний шийдвэрлэсэн тухай санааг харж болно. Ийнхүү шашны бүлэг буюу лам нарыг устгах зорилго бүхий үйл ажиллагаа өрнөсөн.

Коминтерн нь дан ганц лам нартай тэмцэж байсангүй бас монголын нийгмийг удирдаж байсан төрийн зүтгэлтнүүдтэй тэмцэж байсан. Богдын тухай асуудлыг авч хэлэлцэхэд Богдыг хүлээн зөвшөөрөхгүй гэж 12 гишүүн саналаа өгч байхад улс төрийн энэ маш чухал асуудлаар 4 гишүүн санал өгөхөөс түдгэлзсэнийг тэмдэглэх нь зүйтэй” хэмээн бичсэнийг үзвэл тус намын шашин хийдтэй холбоотой шийдвэрийг байнга коминтернд мэдээлж, тэр байтугай намын дотор нэгдмэл байх суурьгүй гишүүдийг дурдаж байсан байна. Монгол улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын төлөөлөгчид Москвад айлчлах үеэр 1937-1941 онд Москвагийн ойролцоох Бутовогийн Коммунаркад улс төрийн хилс хэргээр хэлмэгдэж цаазлагдсан хүмүүсийн баримттай танилцсан бөгөөд түүний дотор 30 гаруй монгол хүн байсан байна.

Хилс хэргээр хэлмэгдсэн эдгээр иргэдийн дотор БНМАУ-ын Ерөнхий сайд, БНМАУ-ын бага хурлын дарга болон яамдын сайд, МАХН-ын хариуцлагатай ажилтнууд багтаж байсан. Тэдгээрээс 25 нь бага боловсролтой, 5 нь дунд, 2 нь бүрэн бус дунд, 3 дээд боловсролтой хүн байсан байжээ хэмээн түүхийн эх сурвалжуудад тэмдэглэгджээ. Хэлмэгдэгсдийн хамгийн залуу нь 1915 онд төрсөн бөгөөд 26 насандаа цаазлагдсан нь Ж.Гэндэн, хамгийн ахмад нь 1887 онд төрж, 54 насандаа мөнх бусыг үзүүлсэн А.Амар байна. Нийт 420 орчим хэлмэгдсэн Монгол иргэн байна гэсэн мэдээ байдаг.

Хууль ёсыг зөрчиж довтолгоог хавтгайруулснаар 1932 оны хавар гэхэд зөвхөн төвийн хорих газруудад 5191 хүн хоригдоход хүрсэн байна. Тэдгээрийн 4610 хүний хэргийг хувьсгалын 11 жилийн ойгоор хэрэгсэхгүй болгож хуваагдсан хөрөнгийг нь буцаан өгөхөөр шийдвэрлэжээ.¹³ Гэвч эдгээр хүмүүсийн хувь заяа дотоодын хамгаалах газрын хяналтад байх болж хожим дахин баривчлагдах үндэс болжээ.

Дээрх хэлмэгдүүлэлтийн зорилгыг авч үзвэл төрлөөр хоморголон устгах зорилго хэмээн тодорхойлоход төвөгтэй. 1948 оны Геноцидын

¹² Т.Баярхүү, “Улаан террор: Монголын улс төрийн хэлмэгдүүлэлт”

¹³ Дэмбэрэлийн Өлзийбаатар, “Монголчууд: Хэлмэгдүүлэлтийн эрин үе”, (Улаанбаатар:2007), 59 дэх тал

гэмт хэргийг таслан зогсоох ба шийтгэх тухай конвенц батлагдсан бөгөөд уг олон улсын баримт бичигт төрлөөр устгах гэмт хэргийн зорилгыг “үндэс, угсаа, арьс үндэс буюу шашин шүтлэг нэгтэй бүлэг хүнийг бүхэлд нь буюу хэсгийг нь устгах зорилгоор үйлдсэн” гэмт хэрэг хэмээн тодорхойлсон. Төрлөөр устгах гэмт хэргийн зорилго нь зөвхөн хүмүүсийг устгах биш, харин нэг бүлэг хүмүүсийг бүрмөсөн устгах бөгөөд энэ нь эдгээр хүмүүсийн сайн сайхныг устгах болон түүх, соёл, шашин, амьдралын хэв маягийг устгах зорилгыг давхар агуулж байдаг. Харин хэлмэгдүүлэлтийг зөвхөн лам нар болон сэхээтнүүдийг устгасан үйлдлээр нь төрлөөр устгах гэмт хэрэг хэмээн үзэхэд учир дутагдалтай. Учир нь хэлмэгдүүлэлт нь тухайн бүлэг хүмүүсийг тахин шүтэх явдлыг зогсоох, иргэдийн итгэл үнэмшлийг сааруулах зорилгоор эдгээр бүлэг хүмүүсийг бүрэн устгах бус, эдгээр хүмүүсийн хувь заяаг дордуулан устгах зорилготой байсан. Түүнчлэн тухайн хүмүүсийн дэлгэрүүлж байсан соёлыг тодорхой бүлэг хүмүүсийн хувьд бус нийт ард түмний дотор түгээн дэлгэрүүлэх явдлыг зогсоох зорилготой байсан нь төрлөөр устгах гэмт хэргийн гэмт санаа буюу зорилгыг мөн л үгүйсгэж байна. Өөрөөр хэлбэл хэлмэгдүүлэлт нь тодорхой нийгмийн бүлгийн устгах гэхээс илүүтэй улс төрийн эсрэг зорилготой байсан учраас төрлөөр устгах гэмт хэргийн тодорхойлолтоос хальсан гэж үзэж болно.

Хэлмэгдүүлэлт нь улс төрийн зорилгоор, зөвлөлт засгийн дарангуйлагчдын гаргасан шийдвэрийн дагуу гүтгэн яллах, хүчээр устгах, нийгэмд нөлөө бүхий хүмүүсийг арилгах зорилготой байсан боловч бүлэг хүмүүсийг устгах буюу төрлөөр устгах зорилгоор хийсэн үйлдэл биш байсан байна. Гэхдээ энэ үйл явдлыг төвлөрсөн, хүчирхийлэлтэй, хүний эрхийг зөрчсөн үйлдэл гэж үзэх нь зүй бөгөөд олон хүн эдгээр үйлдлээс хохирч, амь нас алдаж, олон талт гэмт хэрэг үүссэн юм.

Коронавируст цар тахал ба төрлөөр устгах гэмт хэрэг:

Дэлхий нийтийн хүрээнд **Ковид-19** цар тахал олон сая хүний амь насыг авч одон, эдийн засагт хүнд цохилт өгч, нийгэмд томоохон өөрчлөлтүүдийг бий болгосон аюулт үзэгдлийн нэг яах аргагүй мөн билээ. Эрүүгийн эрх зүйн зарим судлаачид коронавируст цар тахлыг төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг агуулж байж болох талаар санааг гаргасан хэдий ч тус цар тахлыг төрлөөр устгах гэмт хэрэг хэмээн үзэхэд хэд хэдэн шинжийг хангасан байх шаардлага тавигдана.

НҮБ-ээс батлан гаргасан “Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц”-д төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг “үндэс, угсаа, арьс үндэс буюу шашин шүтлэг нэгтэй бүлэг хүнийг бүхэлд нь буюу хэсгийг нь устгах

зорилгоор үйлдсэн (a) бүлгийн гишүүдийн амь насыг хороох; (b) бүлгийн гишүүдийн бие махбод, сэтгэцэд ноцтой гэмтэл учруулах; (c) бүлгийг бүхэлд нь буюу түүний хэсгийг бүрэлгэн устгахад чиглэсэн амьдрал, ахуйн нөхцөлийг санаатайгаар бий болгох; (d) бүлгийн дотор төрөлт зогсооход чиглэсэн арга хэмжээ авах; (e) хүүхдүүдийг нэг бүлгээс нөгөөд хүчээр шилжүүлэх зэргийг хамруулан ойлгохоор заажээ.

Өөрөөр хэлбэл төрлөөр устгах гэмт хэрэг нь санаатайгаар бүлэг хүмүүсийг устгах эсвэл тэдний хүн амыг бүрмөсөн устгахаар чиглэсэн үйлдлүүд байх ёстой.

Харин цар тахлыг төрлөөр устгах гэмт хэрэг эсхүл гэмт хэргийн шинжтэй үйлдэл хэмээн үзэхэд холбогдох хэд хэдэн учир дутагдалтай зүйлс ажиглагдаж буй юм. Учир нь Ковид-19 цар тахал нь дэлхий даяар тараасан гэмт хэргийн шинжтэй санаатай үйлдэл бус, харин байгалийн гаралтай вирусийн тархалт юм. НҮБ-ын Төрлөөр устгах гэмт хэргийн талаар конвенц болон манай улсын Эрүүгийн хуульд заасанчлан төрлөөр устгах гэмт хэрэг нь гэмт санаа буюу «санаатайгаар устгах зорилго» юм. Харин цар тахал нь олон хүний амь насанд хохирол учруулсан боловч энэ нь хэн нэгэн этгээдийн гэмт санаагаар үйлдэгдсэн гэхэд төвөгтэй юм.

Зарим улс орнуудад Ковид-19-ийн эсрэг хэрэгжүүлсэн хатуу хөл хорио, эмнэлгийн системийн ялгаварлан гадуурхалт, мөн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой асуудлууд нь тодорхой бүлгүүдэд ялгавартай нөхцөл байдал үүсгэсэн нь төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг мөн л агуулаагүй байна. Ялангуяа буурай орнууд, эмэгтэйчүүд, өндөр настнууд эсвэл аль нэг угсаа, арьсны өнгө бүхий бүлэг хүмүүсийн амьдралд гарсан ялгаварлан гадуурхалт нь хүний эрхийн зөрчил байж болох ч судлаачид энэ нь төрлөөр устгах гэмт хэрэг гэхээс илүүтэйгээр хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн шинжийг агуулж байж болох юм хэмээх санааг ч дэвшүүлсэн байна.

Эндээс үзвэл Коронавируст цар тахал нь төрлөөр устгах гэмт хэргийн субъектив талын шинжийг үл хангаж байгаа буюу зорилго болон гэмт санаагаараа төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг агуулахгүй байна. Харин цар тахлын үеэр аливаа эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохих ёсоор авч чадаагүй, аливаа үндэс угсаагаар ялгаварлан гадуурхсан үйлдэл байгаа тохиолдолд хүний эрхийн зөрчил болон хариуцлагыг хүлээлгэж болох юм.

V. Дүгнэлт

Төрлөөр устгах гэмт хэргийн хувьд тодорхой бүлэг, үндэстнийг устгах зорилготой систем, төлөвлөгөөт хүчирхийллийг илэрхийлэх бөгөөд анх 1944 онд хуульч Рафаэль Лемкиний судалгаагаар энэ нэр томъёо үүсжээ. Улмаар НҮБ-ын 1948 оны «Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц»-ээр төрлөөр устгах гэмт хэргийг олон улсын гэмт хэргийн нэг төрөл болгон албан ёсоор эрх зүйн баримт бичигт тусгажээ.

Олон улсад төрлөөр устгах гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг тодорхойлсон онолын олон хандлага төлөвшсөн байх агаад тэдгээр нь төрлөөр устгах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг нийгмийн бүтэц, улс төрийн тогтолцоо, эдийн засгийн зөрчилдөөн, цөөнхийг ялгаварлан гадуурхах үзэл хандлага, нийгмийн сэтгэл зүй хандлагын үүднээс авч үзэн, өнөөг хүртэл хэрэглэгдэн тогтжээ. Эдгээр үзэл хандлага нь дэлхий дахины түүхэнд болж өрнөсөн төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдол бүрээр мөн нотлогдож, энд улс орны онцлог бүрээс шалтгаалсан ялгаатай үйл баримтууд тэмдэглэгдэн үлдсэн байна.

Манай улсын хувьд 1948 оны НҮБ-ын «Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц»-д 1966 онд нэгдэн орж, олон улсын өмнө төрлөөр устгах гэмт хэргийн үндэсний хууль тогтоомжоор зохицуулах, хамтран ажиллах үүрэг хүлээсэн ч уг гэмт хэргийг хожмоо 2002 онд анх Эрүүгийн хуульдаа тусгажээ. Монгол Улс төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариуцлага ногдуулах эрх зүйн орчныг сайжруулж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн эсрэг олон улсын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулж буй чухал алхам болсон билээ. Өөрөөр хэлбэл Монгол Улс анх 1926 онд төрөлжсөн Эрүүгийн хуулийн анхны хэлбэр болох “Шүүх цаазын бичиг”-ийг баталсан ч 80 орчим жил эрүүгийн хуульдаа төрлөөр устгах гэмт хэрэг болон бусад хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүдийг хуульчлаагүй байна. Эхэн үеийн хууль тогтоомжуудад төрлөөр устгах гэмт хэргийн талаар тусгайлан заагаагүй хэдий ч социалист эрүүгийн хуульд “хорлон сүйтгэх» зэрэг гэмт хэргийг тусган зохицуулж байв.

Харин 2002 оны Эрүүгийн хуулийн 302 дугаар зүйлд «үндэс, угсаа, арьсны өнгө, хүн ам, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор үйлдсэн аливаа үйлдэл» хэмээн заасан бол 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар төрлөөр устгах гэмт хэргийн шинжийг олон улсын конвенцод нийцүүлэн үндсэн дөрвөн бүлгийг төрлөөр устгах, түүнтэй холбоотой аливаа гэмт үйлдэл болон

ялын хэмжээг шинэчлэн тусгасан.

Төрлөөр устгах гэмт хэргийг Эрүүгийн хуульдаа тусган зохицуулж буй улсуудын хувьд “Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц”-ийн тодорхойлолтоос хол зөрүүгүй байна. Харин зарим онцлог зохицуулалтыг авч үзвэл “нөхөн үржихүйн чадварыг сулруулах”, “бүлгийн бүтцийг сүйрүүлэх” хэмээн үйлдлүүдийг төрөлжүүлэн хуульчилсан нь сайн туршлага болжээ.

Манай улсын хувьд төрлөөр устгах гэмт хэргийн холбогдох тохиолдол гарч байгаагүй боловч зарим судлаачид 1937 оны Их Хэлмэгдүүлэлт, мөн 2019 оны Коронавируст цар тахлыг “төрлөөр устгах гэмт хэрэг”-ийн шинжийг агуулж байж болзошгүй хэмээн таамгийг дэвшүүлээд буй. Хэлмэгдүүлэлтийн тухайд хэдийгээр олон хүнийг санаатайгаар хоморголон устгасан харамсалтай үйл явдал болсон хэдий ч эцсийн дүндээ улс төрийн зорилгоор буюу тухайн бүлэг хүнийг бүлэглэн устгах бус, тэдгээрийг нийгэмд эзлэх байр суурийг бууруулах, тэднийг нийгмээс шахан гаргах зорилготой байсан учир сонгодог утгаараа “төрлөөр устгах гэмт хэрэг”-ийн жишээ болохгүй юм. Харин Коронавируст халдварын хувьд олон хүний амь насыг авч одсон хэдий ч энэ нь давагдашгүй хүчин зүйл буюу хэн нэгэн санаатайгаар халдвар тараасан эсэх нь тодорхойгүй байна. Иймээс гэмт санаа буюу тухайн бүлэг, хүн амыг устгах зорилгоор хийгдсэн үйлдэл хэмээн дүгнэхэд учир дутагдалтай.

Бусад улсуудын хувьд төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдлууд гарсан хэдий ч олон улсын шүүхээр түүний заримд нь шийтгэл ногдуулан, заримд нь шийтгэл ногдуулах хангалттай үндэслэлийг нотолж чадаагүй байна. Эдгээр тохиолдлуудыг судлан үзэхэд төрлөөр устгах гэмт хэрэг дан ганц хүн ам, бүлгийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахаас гадна тухайн онцлог хэв шинж бүхий бүлэг, холбоо хамаарал бүхий улсын соёл, уламжлал, эдийн засаг, шашин шүтлэг, амьдралын нөхцөл зэрэгт үнэлж баршгүй хохирол дагуулж буй юм. Эдгээрт хариуцлага ногдуулахад дан ганц улс дотооддоо шийдэхэд учир дутагдалтай бөгөөд олон улсын хамтын зарчмаар Олон улсын Эрүүгийн шүүх болон бусад холбогдох шүүхүүдээр шийдвэрлэж байна.

Ийнхүү шийдвэрлэхэд олон улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ болох Responsibility to Protect (R2P) буюу Хамгаалах үүргийг улс орнууд холбогдох хууль тогтоомждоо тусгах, түүнийг биелүүлэхийг эрмэлзэх нь улс орон бүр өөрийн нутаг дэвсгэр дээр амьдарч буй хүн амыг хоморголон устгах, дайны гэмт хэргүүд, этник цэвэрлэгээ, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүдээс хамгаалах чухал алхам болох юм.

Энэхүү судалгааны хүрээнд дараах саналуудыг дэвшүүлэв:

- “Энэ хуульд заасан “ноцтой хохирол, хор уршиг” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно” хэмээсэн бол хүнд хохирол гэдэгт илүү эрүүл мэндэд учирсан хохирол буюу Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Гэмтлийн зэрэг тогтоох журам”-д зааснаар “гэмтэх үед амь нас хохирч болох амь тэнссэн байдалд хүргэсэн буюу ердийн явцаараа ихэвчлэн үхэлд хүргэх гэмтэл, гэмтлээс үүссэн үлдэц, уршиг, хөдөлмөрийн ерөнхий чадвар их хэмжээгээр алдагдсан гэмтэл” хэмээн хуульчилсан. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуульд олон улсын конвенцоос өөр хэм хэмжээ тусгагдсан байгаа нь Үндсэн хуульд заасан Олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил баримтална” гэснээс зөржээ. Түүнчлэн 2014 онд батлагдсан “Гэмтлийн зэрэг тогтоох журам” хүчингүй болж “Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам” болон өөрчлөгдсөн. Үүнээс үзвэл Эрүүгийн хуульд “төрлөөр устгах гэмт хэрэг”-ийн улмаас учирсан үнэлгээг “Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц”-д нийцүүлэх, хийдлийг арилгах шаардлагатай.

- Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцод хүний эрүүл мэндэд учирсан ноцтой хохирлоос гадна сэтгэцэд хохирол учруулах үйлдлийг мөн хуульчилсан. Харин манай Эрүүгийн хуульд зөвхөн бүлгийн гишүүдийн бие махбодод учирсан хохирлыг авч үзсэн байна. Иймд сэтгэцэд учирсан хохирлын талаар Эрүүгийн хуульд хуульчлах;

- Шинжлэх ухааны тайлбарын үүднээс Эрүүгийн хуулийн 29.5 дугаар зүйлийг тайлбарласан тайлбар эсхүл хууль хэрэглээний хувьд тус заалтыг Хууль тогтоогч болон Улсын дээд шүүхээс тайлбарласан тайлбар байхгүй байна. Заалтын зарим диспозицийг тайлбарласан тайлбараас иш татан тайлбарлаж болох хэдий ч “албадан зайлуулсан” үйлдлийг хэрхэн тайлбарлах талаар тайлбар байхгүй байгаа нь цаашлаад эрх зүйн хийдлийг үүсгэх, ял завших нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй юм. “Албадан зайлуулах” гэдгийг “байнгын болон түр оршин суугаа газраас өөр газарт хүчээр, хүсэл зоригийнх нь эсрэг нүүлгэх, шилжүүлэх” хэмээн тайлбарлаж болох юм.

- Түүнчлэн манай улсын эрх зүйн тогтолцоотой ижил эрх зүйн тогтолцоо бүхий зарим улсад “нөхөн үржихүйн чадварыг сулруулах” хэмээн хуульчилсан. Хэдийгээр манай улсад “төрөлтийг хүчээр зогсоосон” хэмээн хуульчилсан байх боловч, “нөхөн үржихүйн

чадварыг сулруулах” хэмээн үйлдлийг нэмж хуульчлах нь тус төрлийн гэмт хэргийг хүн төрөлхтний эсрэг бусад гэмт хэргээс ялган зүйлчлэх боломжийг нэмэгдүүлэх юм.

[Ном зүй]

Соводсүрэнгийн Нарангэрэл, Монголын Их Хэлмэгдүүлэлт, Монголын 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн түүхэн явц, түүний үр дагавар, архивын баримт материалд тулгуурласан судалгаа.

С.Эрдэнэболд, “Монголын түүхэн хэлмэгдүүлэлт ба хүний эрх”, Хэлмэгдүүлэлтийн хүний эрхийн зөрчил, түүхэн үр дагаврын талаар судалсан бүтээл.

Үнэн сонин, 1990 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн дугаар.

Т.Баярхүү, “Улаан террор: Монголын улс төрийн хэлмэгдүүлэлт”

Дэмбэрэлийн Өлзийбаатар, Монголчууд: Хэлмэгдүүлэлтийн эрин үе, Улаанбаатар 2007 он.

Ann Tusa, John Tusa, The Nuremberg Trial. Atheneum, 1983

Michael R. Marrus, The Nuremberg War Crimes Trial 1945–46: A Documentary History. Bedford/St. Martin's, 1997

Alison Des Forges, Leave None to Tell the Story: Genocide in Rwanda. Human Rights Watch, 1999

Johan Hagan, Justice in the Balkans: Prosecuting War Crimes in the Hague Tribunal. University of Chicago Press: 2003

Craig Etcheson, After the Killing Fields: Lessons from the Cambodian Genocide. Praeger Security International, 2005

Van der Vyver, Johan, The International Criminal Court and the Concept of Mens Rea in International Criminal Law, (University of Miami International & Comparative Law Review, 2007

Understanding the International Criminal Court, 2020,

Emory Public Law Research Paper, Available at SSRN: <https://ssrn.com/abstract=1940084>

Understanding the International Criminal Court

<https://www.icc-cpi.int/sites/default/files/Publications/understanding-the-icc.pdf>

[Abstract]

**The Doctrine of Jus Cogens: Conceptual Foundations for
Defining the Crime of Genocide and Issues in Improving
Domestic Legal Regulation**

Altangerel Batkhuyag

Master of Laws (LL.M.).

*Lawyer, Researcher at the Department of Case Management,
Information and Research of the Supreme Court of Mongolia
Ulaanbaatar, Mongolia*

This article examines the crime of genocide within the framework of jus cogens norms of international law, analyzing its conceptual and legal foundations and assessing how it has been incorporated into Mongolia’s domestic legal system, as well as identifying ways to improve it.

One of the key findings of the study is that the process of codifying genocide as a criminal offense in Mongolia has historically been slow. It was not until 2002 that genocide was first fully recognized as a distinct crime in national criminal legislation. Although the current Criminal Law (2017) largely aligns with international standards regarding the crime of genocide, the study reveals that certain provisions remain ambiguous, particularly those related to mental harm inflicted upon a group and the definition of “forcible transfer.”

Based on its findings, the article proposes policy-level recommendations aimed at bringing Mongolia’s criminal law into closer conformity with international norms, strengthening preventive mechanisms, and clarifying standards of evidence. The study seeks to provide a more precise theoretical and practical understanding of genocide and to contribute to the improvement of the domestic legal framework.

[Keywords]

Jus cogens; Genocide; International criminal law; Dolus specialis; ICTY; ICTR; ICC; Criminal Law of Mongolia; Prevention mechanisms; Human rights protection.